


Овог нэр: Лхаеязам овогтой Уранцэцэг
Байгууллагын нэр: “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ –ын Хөгжлийн хэлтэс.
Албан тушаал: Бүтээмж, инновацийн мэргэжилтэн



д/д	Сургалтын нэр	Огноо, хаана	Зохион байгуулагч	Олж авсан мэдлэг	Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр
А	Дотоод сургалт:				
1	Бүтээмжийн мэргэжилтэн бэлтгэх	2006 он. УБ хот.	ҮБХТ	Бүтээмжийн хөдөлгөөн, бүтээмж дээшлүүлэх арга хэрэгслэлүүдийн талаарх мэдлэг авч, гадаад дотоодын олон байгууллагуудын туршлагаас суралцсан.	<p>2005 Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ–ын Баяжуулах үйлдвэрийн хамт олон “Бүтээмж дээшлүүлэх Эрдэнэт хөтөлбөр” нэртэйгээр бүтээмжийн хөдөлгөөнийг эхлүүлсэн түүхтэй.</p> <p>2006 оноос Баяжуулах үйлдвэрийн Бүтээмжийн мэргэжилтнээр ажиллаж эхэлсэн.</p> <p>-2008 онд Баяжуулах фабрик Монгол улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит “Үндэсний бүтээмжийн шагнал” хүртсэн.</p> <p>-2010 оноос Баяжуулах фабрикт эхэлсэн бүтээмжийн хөдөлгөөн “Хүний хөгжилд тулгуурлан бүтээмжийг дээшлүүлэх” шатанд шилжсэн.</p> <p>-2012 онд Эрдэнэт үйлдвэрийн Хүний нөөцийн хэлтсээс “Хүн-Эрдэнэ” хөтөлбөрийг боловсруулан, 23 цехийг бүтээмжийн хөдөлгөөнд татан оролцуулсан.</p> <p>-2015 онд Баяжуулах фабрикийн бүтээмжийг дээшлүүлэх ажиллагаанд МБТ-аар Олон улсын стандартын дагуу “Бизнесийн төгөлдөршилийн үнэлгээ” хийлгэж нь үнэлгээгээр 615 оноо авсан.</p> <p>-2014-2015 онд Эрдэнэт үйлдвэрийн Хөгжлийн хэлтсийн дэргэд “Инновацийн төв” байгуулагдан, Бүтээмж, Инновацийн тогтолцоог хэрэгжүүлэх журмууд батлагдсан.</p> <p>-2016 оноос бүтээмжийг дээшлүүлэх ахисан түвшний арга хэрэгсэл 6 сигма, Бенчмаркинг, Ногоон бүтээмжийн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн.</p> <p>-2020 оноос бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх асуудлыг цогц байдлаар авч үзэн удирдлагын бүх түвшинд байгууллагын нийт ажиллагчдын идэвх оролцоо болон удирдлага-ажиллагчдын хамтын ажиллагаанд тулгуурласан бүтээмжийг таньж мэдэх, түүнийг хэмжих, нөлөөлөгч хүчин зүйлсийг тооцон шинжилж үнэлгээ өгсний үндсэн дээр дээшлүүлэх арга замуудыг тодорхойлон төлөвлөж хэрэгжүүлсэн үр дүнг тооцох иж бүрэн асуудлыг хамарсан тогтолцоог хэрэгжүүлж байна.</p> <p>-“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь үйл ажиллагааны явцад хуримтлагдсан мэдлэгийг бүтээлчээр ашиглах, ажилтнуудын байнга өөрчлөн сайжруулах хүсэл эрмэлзлийг урамшуулан дэмжих орчин нөхцөлийг бүрдүүлэн ажилласнаар 2005-2021 онд сайн саналын системээр дамжуулан ажил сайжруулахтай</p>
2	“Тоёото үйлдвэрлэлийн систем”	2007 он. УБ хот	АББ, ҮБХТ		
3	Бүтээмжийн мэргэжилтний ахисан түвшний сургалт	2015, 2017			
4	Монголын Бүтээмжийн Байгууллага Азийн бүтээмжийн байгууллагын хамтарсан сургалтууд	2008-2021 он. УБ.	МБТ		

				холбоотой нийт 52269 санал гаргаж, тэдгээрийн 60 орчим хувийг үйлдвэрлэлд хэрэгжүүлжээ. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т ажилтан бүрийн оролцоотойгоор “Сайн саналын систем”, “5 сайн үйлс”, “Бүтээмж чанарын дугуйлан” гэсэн арга хэрэгслүүдээр дамжуулан тасралтгүй сайжруулалтын үндсэн зарчмыг баримтлан хэрэгжүүлж байгаа байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх ажил нь үйлдвэрийн газрын үйл ажиллагааны нэг бүрэлдэхүүн хэсэг, механизм, соёл болон төлөвшөөд байна.	
Б	Гадаад сургалт:				
	“Тоёото үйлдвэрлэлийн систем”	Япон.Тоёота хот. 2007 он.	АББ, ҮБХТ	Япон улсын бүтээмжийн хөдөлгөөн, тэргүүн туршлага, бүтээмж дээшлүүлэх анхан шатны аргууд, ТҮС-ийн мөн чанар, ач холбогдол	Тоёота үйлдвэрийн тэргүүн туршлагаас суралцан 5S, Кайзен саналын системийн хэрэгжүүлэлтийг идэвхжүүлсэн.
	“Бүтээмж, чанарын мэргэжилтэн бэлтгэх”	Сингапур. 2009 он.	Сингапурын Темасек сан, ҮБХТ	Сингапурын бүтээмжийн хөдөлгөөний тухай, 5S, кайзен саналын систем, чанарын дугуйлан зэрэг бүтээмж дээшлүүлэх арга хэрэгслүүд, тэдгээрийн онцлог, хэрэглээ, бизнесийн төгөлдөршил, чанарын нэгдсэн удирдлага, төрийн үйлчилгээний бүтээмж, Сингапурын тэргүүн туршлагауд	Баяжуулах фабрикийн Бүтээмж чанарын дугуйлангуудын үйл ажиллагааг төсөл хэлбэрт шилжүүлэн, түүнийг хэрэгжүүлэх, үнэлэх, дүгнэх механизмыг тогтоосон
	“Бүтээмжийн арга хэрэгслүүд ба техникүүд”	2016 он. Онлайн	АББ	Анхан шатны түвшинд бүтээмж, чанар, өрсөлдөх чадвар, Азийн бүтээмжийн хөдөлгөөний хөгжил, бүтээмжийн мэргэжилтний тухай, бүтээмжийн хэмжилт, бүтээмж дээшлүүлэх үндсэн арга хэрэгслүүд, чанарын нэгдсэн удирдлага гэсэн модуль сэдвүүдээр, ахисан түвшинд бүтээмжийн хэмжилтэнд iCompass программыг ашиглах нь, бизнесийн төгөлдөршил, лийн, чанарын хяналтын статистик арга хэрэгслүүд, үр ашгийн урсгалын зураглал, материалын урсгал зардлын тооцоолол	- Эрдэнэт үйлдвэрийн ажилтнуудад Бүтээмжийг дээшлүүлэх арга хэрэгслүүдийн талаарх мэдлэг олгох Модуль сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулан, сургултуудыг жил бүр төлөвлөн гүйцэтгэж байна. “Бүтээмжийн анхан шатны арга хэрэгсэл” 8- цаг, Бүтээмжийн ахисан шатны арга хэрэгсэл – 8 цаг, 6 сигма – 24 цагийн хичээлээр ажилтнуудад мэдлэг олгож байна. - Бүтээмжийн хөдөлгөөнийг менежментийн тогтолцоо руу нь хөтлөхөд үйл ажиллагаагаа чиглүүлэн Эрдэнэт үйлдвэрийн “Бүтээмжийн хэмжилт шинжилгээний аргачлал”-ыг боловсруулсан.
В	Цаашдын ур чадвар дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага:				
	Бүтээмжийн менежментийн тогтолцооны тэргүүн туршлагаас, “6 сигма”, “Материалын урсгал зардлын тооцоолол” аргын гүнзгийрүүлсэн мэдлэг, төслийг хэрэгжүүлсэн тэргүүн туршлагаас суралцах,				



Овог нэр: Лууваанчиг овогтой Дэлгэрмаа
Байгууллагын нэр: “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ –ын Хөгжлийн хэлтэс.
Албан тушаал: Бүтээмж, инновацийн мэргэжилтэн

Сургалтанд хамрагдсан он, сар, өдөр:

- **“Бүтээмж, чанарын мэргэжилтэн бэлтгэх” 21 хоногийн сургалт**
(Сингапурын Темасек сан, Монголын Бүтээмжийн Төвийн хамтарсан төслийн хүрээнд 2009 оны 10-р сард Сингапур улсад зохион байгуулагдсан),

Сургалтаас олж авсан мэдлэг:

Сингапурын бүтээмжийн хөдөлгөөний тухай, 5S, кайзен саналын систем, чанарын дугуйлан зэрэг бүтээмж дээшлүүлэх арга хэрэгслүүд, тэдгээрийн онцлог, хэрэглээ, бизнесийн төгөлдөршил, чанарын нэгдсэн удирдлага, төрийн үйлчилгээний бүтээмж, Сингапурын тэргүүн туршлагууд

- **“Бүтээмжийн арга хэрэгслүүд ба техникүүд”**
(Азийн бүтээмжийн байгууллагын анхан ба ахисан түвшний онлайн сургалт, 2016 оны 5 сарын 01 – 9 сарын 30)

Сургалтаас олж авсан мэдлэг:

Анхан шатны түвшинд бүтээмж, чанар, өрсөлдөх чадвар, Азийн бүтээмжийн хөдөлгөөний хөгжил, бүтээмжийн мэргэжилтний тухай, бүтээмжийн хэмжилт, бүтээмж дээшлүүлэх үндсэн арга хэрэгслүүд, чанарын нэгдсэн удирдлага гэсэн модуль сэдвүүдээр, ахисан түвшинд бүтээмжийн хэмжилтэнд iCompass программыг ашиглах нь, бизнесийн төгөлдөршил, лийн, чанарын хяналтын статистик арга хэрэгслүүд, үр ашгийн урсгалын зураглал, материалын урсгал зардлын тооцоолол

Хэрэгжүүлсэн төсөл, сургалтууд:

2005 онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ–ын Баяжуулах үйлдвэрийн хамт олон “бүтээмж дээшлүүлэх Эрдэнэт хөтөлбөр” нэртэйгээр бүтээмжийн хөдөлгөөний нээлтийг хийж байсан түүхтэй. Улмаар 2008 онд Баяжуулах үйлдвэр нь Монгол улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит үндэсний бүтээмжийн шагнал хүртэж, 2012 оноос үйлдвэрийн бусад 23 цех нэгжид бүтээмжийн хөдөлгөөн хэрэгжиж эхэлсэн бөгөөд, өнөөдөр бүтээмж дээшлүүлэх үйл ажиллагаа нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын соёлын нэг хэсэг болжээ. Бүтээмж дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2005 оноос сайн саналын систем, бүтээмж чанарын дугуйлан, ажлын байрны соёл-5 сайн үйлс зэрэг арга хэрэгслүүд хэрэгжсэн бол 2016 оноос процессын гологдлыг бууруулах “6 сигма”, үйл ажиллагааны хэмжилт үнэлгээний “бизнесийн төгөлдөршил” системийг нэвтрүүлж эхэлсэн.

Бүтээмжийн хөдөлгөөнийг эхлүүлснээр нийт ажилтнуудын бүтээмжийн талаарх ойлголт, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр тасралтгүй сургалт, хөгжлийн арга хэмжээг зохион байгуулж ирсэн. Тухайлбал, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь бүтээмж-инновацийн модуль сургалтын хөтөлбөр боловсруулж, жил бүр сургалтын нэгдсэн график гарган байгууллагын нийт ажилтнуудад чиглэгдсэн сургалтыг тасралтгүй зохион байгуулж, жил бүр ойролцоогоор 1000 гаруй ажилтнуудыг хамруулдаг.

Цаашдын үр чадвар дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага:

Бизнесийн сайжруулалтын арга хэрэгслүүд, тэдгээрийн хэрэглээ, тэргүүн туршлага.



Овог нэр: Одсоргочоо овогтой Булганчимэг

Сургалтанд хамрагдсан он сар өдөр: 2015 оны 5 сард бүтээмжийн мэргэжилтэн бэлтгэх анхан шатны сургалт, 2020 оны 12-р сард бүтээмжийн мэргэжилтэн бэлтгэх ахисан шатны сургалтанд хамрагдсан.

Сургалтаас олж авсан мэдлэг: Анхан шатны сургалтнаас бүтээмжийн тухай ерөнхий ойлголт, багаар ажиллах дасгал ажлуудын жишээ, ахисан шатны сургалтнаас хэмжилт шинжилгээний тухай ерөнхий ойлголтууд авсан.

Хэрэгжүүлсэн төсөл, сургалтууд: Бүтээмжийн анхан шатны сайн саналын системийн тухай ойлголтын сургалт, 5 сайн үйлсийн тухай сургалт, бүтээмж чанарын дугуйлангийн тухай сургалт.

Хамгийн сайн хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд:

Цаашдын ур чадвар дээшлүүлэх хэрэгцээ шаардлага: Цаашид бүтээмжийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, ахисан шатны онол практик хосолсон тодорхой кейстэй сургалтанд суух шаардлага байна.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Бүтээмж, инновацийн мэргэжилтний мэдээлэл

1. Овог нэр: Ёндонжамцын Мөнхтунгалаг
2. Сургалтад хамрагдсан он.сар.өдөр:
 - 2020.12.16-12.18, Бүтээмжийн мэргэжилтэн бэлтгэх ахисан шатны сургалт
 - 2020.07.27-08.07, Мэдлэгийн менежмент
 - 2019 ISO9001 Чанарын менежментийн стандарт, Процессын хандлага, процессын зураглал, загварчлал, Стратеги төлөвлөлт
 - 2018.05.30-31, “Бүтээмжээр дамжуулан бизнесийн төгөлдөршлийг сайжруулах менежментийн тогтолцоо”, Азийн бүтээмжийн байгууллага, Монголын бүтээмжийн төвийн хамтран зохион байгуулсан сургалт
 - 2018.01.17-01.28 “Япон маягийн менежмент ба 5S”, Кайзен холбоо
 - 2017.11.06-08, “Бүтээмжийн статистик ба Мальколм балдрижийн загварт суурилсан бүтээмжийн менежментийн тогтолцоо” Бүтээмжийн мэргэжилтний ахисан түвшний сургалт
 - 2016.10.24-11.04, “6 сигма, КРІ гүйцэтгэл” Бүтээмжийн мэргэжилтний ахисан түвшний сургалт



2016.05.01-09.30, Self-learning e-Course on Productivity Tools and Techniques (Basic), Self-learning e-Course on Productivity Tools and Techniques (Advanced), Productivity Organization

2015.10 сард, “Эрчим хүчний менежмент, ISO50001 стандарт”-ын танилцуулах сургалт

2014.11 сард, “Кайзен” сургалт, Монголын бүтээмжийн төв

2013.12 сард, “Бүтээмжийн мэргэжилтэн бэлтгэх анхан шатны сургалт”, Монголын бүтээмжийн төв

2013.05.13-14, “Чанарын төгөлдөршил” сургалт, Монголын бүтээмжийн төв

3. Сургалтаас олж авсан мэдлэг:

4. Хэрэгжүүлсэн төсөл сургалтууд:

5. Хамгийн сайн хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр:

Ё.Мөнхтунгалаг нь 2015 оны 02-р сараас Хөгжлийн хэлтсийн Инновацийн төвд бүтээмжийн үйл ажиллагаанд инженерээр ажиллаж, үйлдвэрийн газрын бүтээмжийн үйл ажиллагааг өрнүүлэх, сайжруулах, хөгжүүлэх, идэвхжүүлэх, сайн саналын систем, БЧД, 5С-ийн арга хэрэгслүүдийн хэрэгжилтийг хангах, бүтээлч санал, санаачилгын мэдээллийн системийг боловсронгуй болгох, ахисан шатны арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх, бүтээмжийн модуль сургалтын системийг бүрдүүлэх, цех нэгжүүдийн бүтээмжийн менежер, чиглүүлэгч нарт зөвлөгөө өгөх зэргээр ажиллаж байна. 2016 оноос "6 сигма" арга хэрэгслийг нэвтрүүлэх, төсөл хэрэгжүүлэх зорилгоор, ногоон бүстийн сургалтыг ИТА-нуудад явуулж эхэлсэн. Мөн Бизнесийн төгөлдөршил 1000 онооны системийг өөрийн ажлын онцлогт хөрвүүлэн үнэлгээ хийх ажлыг хийсэн.

Сүүлийн 5 жилд хийсэн ажлуудаас:

- Хамтын ажиллагааны чиглэлээр 60 орчим байгууллагад Эрдэнэт үйлдвэрт хэрэгжиж буй бүтээмж дээшлүүлэх ажил, хөтөлбөрүүдийг танилцуулж өөрсдийн тэргүүн туршлагыг түгээсэн.

- Үйлдвэрийн хэмжээнд зохион байгуулсан 1000 инженерийн зөвлөгөөний зохион байгуулалтын хэлбэр, техник ажиллагаануудыг хариуцан ажиллаж 2018 онд Эрдэнэт үйлдвэрийн 40 жилийн ойн хүрээнд зөвлөгөөний цар хүрээг өргөжүүлж, Монголын төр болон бизнесийн байгууллагуудын менежментийн ухаан, ажлын арга барил, тасралтгүй сайжруулалтын тэргүүн туршлагыг хуваалцах ажлын хамтран зохион байгуулсан.

- Мастерууд, мастерт бэлтгэгдэж буй ажилтнуудын манлайллыг дээшлүүлж, үйлдвэрийн газрын удирдах ажилтан бэлтгэх соёл, карьер менежментийг хөгжүүлэх “Мастерын манлайлал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэгт ажилласан. Үүнд, “Манай манлайлагчид” ахмад үеийн туршлагаас суралцах уулзалт, “Миний ноу-хау” туршлага солилцох өдөрлөг Мастеруудад зориулсан сургалт Чөлөөт уулзалтын арга хэмжээнүүд зохион байгуулахад сургалт явуулахын зэрэгцээ хувийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг хэрэгжүүлэхэд зөвлөн чиглүүлэгчээр ажилласан.

- Олон улсын туршлага болсон “Бизнесийн төгөлдөршил” 1000 онооны үнэлгээний стандартын дагуу өөрсдийн бүтээмжийн үйл ажиллагааны хэрэгжилтийн түвшин тогтоох үнэлгээний загварыг боловсруулах, тус загвараар үнэлгээг хийж гүйцэтгэхэд оролцсон.

- Эрдэнэт үйлдвэрийг 2018-2032 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, компанийн алсын хараа, эрхэм зорилго, тогтвортой хөгжлийн цогц бодлого, томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд компанийн бүтцийн нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулах, ажлын ачааллыг нягтруулах, давхардлыг арилгах, оновчтой зохион байгуулах зорилгоор судалгаа хийж, санал боловсруулах ажлын хэсэгт ажилласан. Судалгаанд хүчин зүйлсийн хоорондын хамаарал, холбоог судлахад түгээмэл ашиглагддаг матриц судалгааны аргыг ашигласан бөгөөд матрицын хөндлөн тэнхлэгт компанийн тогтвортой хөгжлийн бодлогын 33 зорилтыг, матрицын босоо тэнхлэгт хэлтсүүдийн 522 үндсэн чиг үүргийг байршуулж, хамаарлыг тодорхойлох талбаруудад тасралтгүй сайжруулалтын PDCA* циклийн тэмдэглэгээнүүдийг хийсэн.

- Сүүлийн 5 жилд 4000 орчим ажилтанд Бүтээмж дээшлүүлэх анхан болон ахисан шатны арга хэрэгслүүдийг зааж, сургах ажлуудыг, 30 гаруй бүтээмжийн мэргэжилтэн, чиглүүлэгчдэд Бүтээмжийн үйл ажиллагааны ахисан шатны болон хувь хүний хөгжил, ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулж сургалт явуулсан.

Дээрх ажлуудын үр дүнд үйлдвэрийн газрын сайн саналын системээр дамжуулан ажилтнуудаас ажил сайжруулахад чиглэгдсэн санал санаачилга 35 хувь, саналын хэрэгжилт 20 орчим хувиар, сайн саналын систем дэх ажилтнуудын оролцоо жил бүр 4-6 хувиар өссөн. Мөн Бүтээмж чанарын дугуйлангийн төсөл, жижиг сайжруулалтын ажлын хэрэгжилт 2 дахин өссөн.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ажилтнууд сайн саналын системээр дамжуулан өдөрт 15 санал гаргаж, үүний 8 нь хэрэгжиж, байгууллагад сайжруулалт хийгдэхгүй нэг ч өдөр алга байгаа нь бүтээмжийн хөдөлгөөний амжилт, үнэ цэнэ юм. Үүний үр дүнд ажилтан, хамт олон өөрсдийн санаачилгаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тулгамдаж буй, бэрхшээлтэй асуудлуудыг илрүүлэн шийдвэрлэснээр ажлын байрны орчин нөхцөлүүд дээшилж, зөрчил, доголдол буурч, ажил хөнгөвчилсөн, үр ашиггүй зардлуудыг бууруулсан, тоног төхөөрөмжийн ашиглалтыг дээшлүүлсэн, үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангасан, эрсдэлийг арилгасан зэрэг эерэг үр дүнгүүд гарч байна. Эдгээрээс хамгийн чухал нь ажилтнуудын бүтээлч хандлага дээшилснээр үйлдвэрийн газрын хэмжээнд бүтээмжийн соёл, ухамсар, үзэл баримтлал төлөвшиж байгаа явдал юм.